

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Говьсүмбэр аймгийн “Биеийн тамир спортын газар”-ын  
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2020/37/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойр хот  
2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа  
Утас: 70543156  
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn  
Аудитын менежер: Г.Наранбаяр  
Утас: 70543179  
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn  
Аудитор: Д.Оюунбат  
Утас: 99973399  
Цахим хаяг: Oyuna200702@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АИХТ ТӨБЗГ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХОАТ НБББББ	Хувь хүний орлогын албан татвар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	4
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8-9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
3     Менежментийн захидал.....	11
3.1. Үндсэн хөрөнгийн ТАЛААР .....	12
3.2. Дотоод хяналтын ТАЛААР .....	13
4     Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14-22



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, З дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: govismumber@audit.gov.mn

2020-02-17 № 16

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН  
ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
Б.БУЯНТОГОХ ТАНАА**

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн "Биеийн тамир, спортын газар"-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

### **Зөрчилгүй санал дүгнэлт**

Говьсүмбэр аймгийн "Биеийн тамир, спортын газар"-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлэгдсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### **Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Говьсүмбэр аймгийн "Биеийн тамир, спортын газар"-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус газарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуванс.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### **Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн

.. 008020047

болов Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Говьсүмбэр аймгийн "Биеийн тамир спортын газар"-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч Б.Буяントогоход танилцуулж байна.

Энэхүү тайландаа үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн "Биеийн тамир спортын газар"-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн "Биеийн тамир спортын газар"-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 03-наас 2020 оны 02 дугаар сарын 06-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хургуулэхээр төлөвлөн, "Саруул баян уул-Аудит" ХХК-ийн аудитор Д.Оюунбат хариуцаж хэрэгжүүлэв.

Аймгийн Биеийн тамир, спортын газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг "Саруул баян уул-Аудит" ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалыар баталгаажуулсан болно.

#### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Аймгийн "Биеийн тамир спортын газар" нь "Аймаг орон нутагт биеийн тамир, спорт хөгжих орчин, нөхцлүүдийг бүрдүүлэн эрүүл чийрэг бие бялдартай иргэд, хамт олныг төлөвшүүлж, биеийн тамир, спортыг нийтийн хүртээл болгон, сонгон хөгжүүлж буй спортын төрлүүдийг түлхүү хөгжүүлэн өндөр зэрэг цолтой тамирчдыг бэлтгэнэ" гэсэн эрхэм зорилгын хурээнд 2019 онд "Хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэх, биеийн тамир чийрэгжүүлэлтийн арга хэмжээг өргөн хүрээтэй үр дүнтэй зохион байгуулах" гэсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

2019 онд Сүмбэр сумын ЗДТГазар, Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран ажиллах ажлын хурээнд аймгийн суугаа волейболын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж нийт 6 багийн 40 гаруй иргэд оролцсон ба арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон асран хамгаалагч нарын дунд зохион байгуулж нийт 50 гаруй иргэд оролцсон.

Ийнхүү Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмд оролцох боломжийг нэмэгдүүлснээр тэдний биеийн тамир спортоор хичээллэх орчин нөхцөл бүрдсэн хамтын ажиллагаа тогтмолжсон.

Албан байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдэд Өглөөний дасгалын ач холбогдолыг сурталчилан таниулах, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлж, хүн амыг эрүүл, стрессгүй, амьдралын хэв маяг, дадлыг бий болгох үүднээс "Өглөөний агаар-Идэвхтэй хөдөлгөөн" сэдэвт өглөөний гүйлт 2019 оны 05 сарын 09-ны өглөөний 07 цагаас "Сүмбэр гарден" амралт, соёлын хүрээлэнд эхлэн 06 сарын 13-ны байдлаар тогтмол 56 байгууллагын давхардсан тоогоор 1,562 албан хаагч, иргэн хамрагдаад байна. Өглөөний гүйлт, дасгалыг олон хувилбар ашиглан зохион байгуулж байна. Жишээ нь. Волейбол, хөлбөмбөг, Иог, Аэробик, Хийн дасгал.... гэх мэт. Үүний үр дүнд аргэдэдийг хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлж, хүн амыг эрүүл, стрессгүй, амьдралын хэв маяг, дадал бий болгох, эрүүл бие бялдартай иргэд төлөвшиж байна.

Аймгийн спортын салбар холбоодын тэргүүн болон дасгалжуулагч багш нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулж, сургалтанд аймгийн 17 спортын салбар холбоод оролцож, салбар холбоодуудын тэргүүнүүдтэй хамтын ажиллагааны гэрээг байгуулсан байна. Үр дүн нь Орон нутагт спортын салбар холбоодын бие даан ажиллуулах, чадавхжуулах, салбар холбоогоор дамжуулан иргэдийг спортоор хичээллүүлэх, орон нутагт анхан шатны тэмцээн уралдаан зохион байгуулах. Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох зардлыг салбар холбоодод хуваарилан ажиллаж хэвшсэн.Хамтын ажиллагаа улам бэхжиж байна.

2019 онд усан спорт сургалтын төвөөр давхардсан тоогоор нийт 6,843 иргэн үйлчлүүлж фитнесийн төвөөр нийт давхардсан 140 иргэн тогтмол хичээллэж өмнөх оноос 48,5 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

Сэлэнгэ аймагт 2019 оны 06 сарын 30-нд Эрдэнэт хотод болсон "Fina world aquatics day" нэрэмжит тэмцээнд Говьсүмбэр аймгийн баг тамирчид амжилттай оролцож 1 алт, 18 мөнгөн, 11 хүрэл медаль хүртсэн.

"viszta" клубын нэрэмжит усан спортын нээлттэй олон хотын тэмцээн 2019 оны 10 сарын 12,13-нд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулагдаж Говьсүмбэр аймгийн Говийн усчид амжилттай арвин оролцож алт мөнгө хүрэл медалууд хүртсэн байна.

Усан спортоор хичээллэгчдийн хүрээ тэлж өмнөх оноос 3,3 хувиар өссөн ба усан спортын тамирчдын амжилт эрс өссөн байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллага нь БСШУСС-ын 2017 оны А/40 дугаар тушаалаар баталсан НБББББ-ийг мөрдөж байгаа бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн "Биеийн тамир, спортын газар"-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Гүүк софт" ХХК-ийн "AXPLORER" програм хангамж ашиглаж байна.

Аймгийн "Биеийн тамир, спортын газар"-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар аймгийн "Биеийн тамир, спортын газар"-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд эрсдэлтэй асуудалд 31 горим 9 сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 03 дугаар улирлын санхүүгийн үр тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 304,849.6 мянган төгрөгөөс тооцон 3,048.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 679,759.0 мянган төгрөгөөс тооцон 6,797.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, материаллаг байдал төлөвлөлтийн үеэс 3,749.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төлөвлөлтэд 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн зардлын дүнг сонгосонтой холбоотой болно.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аймгийн "Биеийн тамир спортын газар"-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос мянган төгрөгөөр буюу 0,05 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган  
төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	43,065,9	53,544.8	10,478.9
Үндсэн хөрөнгө	2,358,434.1	2,303,815.0	-54,619.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,401,500.0</b>	<b>2,357,359.8</b>	<b>-44,140.2</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,401,500.0	2,357,359.8	-44,140.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,401,500.0</b>	<b>2,357,359.8</b>	<b>-44,140.2</b>

Авлага дансанд өөрчлөлт ороогүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10,478.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан бараа материалыг тухайн онд зарцуулаагүйтэй холбоотой байна..

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 43,065.9 мянган төгрөг байсан бөгөөд тайлант хугацаанд 24,054.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 9,453.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, байгууллагын даргын 2019 оны А/31 дугаар бүхий тушаалаар 4,122.4 мянган төгрөгийн бараа материал акталж, 53,544.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Бараа материалын данс нь бичиг хэргийн материал 1,159.0 мянга, аж ахуйн материал 51,962.1 мянга, сэлбэг хэрэгсэл 206.6 мянга, эм боох материал 217,1 мянга, нийт 53,544.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө данс нь оны эхэнд 2,501,637.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба өөрчлөлт ороогүй байна.

Биет бус хөрөнгө, Засгийн газрын сан болон хөрөнгийн дахин үнэлгээ дансуудад өөрчлөлт ороогүй байна.

Цэвэр өмчийн дүн 44,140.2 мянган төгрөгөөр буурч 2,357,359.8 мянган төгрөг болсон нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 71701 буюу биеийн тамир спорт гэсэн 1 хөтөлбөрт зориулан 337,238.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 337,224.2 мянган төгрөг зарцуулж, 14.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нийт зардлын 306,238.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 22,000.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардал 337,238.0 мянган төгрөг буюу 99.9 хувийн гүйцэтгэлтэй, 14.0 мянган төгрөгийн хэмнэлтийг төвлөрүүлсэн байна. Энэ нь цалин хөлснөөс 0.2 мянга, тогтмол зардлаас 7.0 мянга, томилолтын зардлаас 6.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 0.5 мянга, нийт 14.0 мянган төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайландаа үндсэн санхүүжилт 315,238.2 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 22,093.0 мянга, нэмэлт санхүүжилт 81,811.7 мянга, нийт 419,142.9 мянган төгрөгийн орлогыг тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайландаа үндсэн санхүүжилт 315,238.2 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 22,093.0 мянга, нэмэлт санхүүжилт 81,811.7 мянга, нийт 419,142.9 мянган төгрөгийн орлогыг тайлагнасан байна.

**Нэмэлт төсөв:** ОНХС-аас тэмцээн уралдааны зардалд 70,800.0 мянга, үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөө давсан орлого 6,183.0 мянга, автобусны үйлчилгээний орлого 458.7 мянга, аймгийн ЗДТГ-аас автобусны цалин, шатахууны зардалд 1,826.0 мянга, Улсын биеийн тамир спортын хорооноос бусийн уралдаан тэмцээний зардалд 2,544.0 мянга нийт 81,811.7 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар бүртгэж, уралдаан тэмцээний зардалд 73,344.0 мянга, цалин, шимтгэлд 591.7 мянга, шатахууны зардалд 1,672.0 мянга; бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 683.0 мянга, халаалтын зардалд 4,000.0 мянга, нийт 81,811.7 мянган төгрөг зарцуулсан байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 41 эрсдэл, нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 222,889.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 216,643.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,183.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2 алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд:

- Цалингийн зардлаас 63.0 мянган төгрөгийн хоолны зардлыг томилолтын зардалтай давхардуулан олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтыг тус тус зөрчсөн ба үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангaaгүй байна

**Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт бичив.**

2. Буцааж тушаасан ээлжийн амралтын 167.7 мянган төгрөгийг буруу бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтыг тус тус зөрчсөн ба үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна

**Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.**

2. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 216,475.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтыг тус тус зөрчсөн ба үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.**

3. Тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө сүүлийн 2 жил дараалан 6,000.0-7,000.0 мянган төгрөгөөр давж биелэгдэж байхад төлөвлөлтийг тогтмол 22,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, төлөвлөгөө давсан орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалт, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зардлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.4, 3.4.2 дахь заалтыг тус тус зөрчсөн ба үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх тухай 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

**2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитын явцад анхаарал татах асуудал гараагүй болно.

**2.12. Шилэн дансны мэдээлэл**

Аймгийн Биөийн тамир, спортын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 123 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

**2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

## 2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид аймгийн "Биеийн тамир, спортын газар"-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Аймгийн "Биеийн тамир, спортын газар"-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь аймгийн "Биеийн тамир, спортын газар"-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланда тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланда шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдоор нь эрэмбэлэн үзүүлэв.

Дараах зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3.1. Үндсэн хөрөнгийн талаар

#### Илрүүлэлт

Ашиглалтын хугацаа дууссан 43 нэр төрлийн, 166 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй ашиглагдаж байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 18 дугаар зүйлийн 18.1, ТӨБЗГ-ын 2019.06.18-ний өдрийн 271 тогтоолын 6 дугаар зүйлийн 6.2.1, 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд үнэлгээ гэсэн батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.

#### Зөвлөмж

Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг акталж устгах буюу дахин үнэлж бүртгэх

#### Хариуцах ажилтан

Дарга Б.Буяントонтох  
Нягтлан бодогч Б.Лүнгэрэгжанцан

#### Эрсдэл

Тайлангийн үнэн зөв байдлыг алдагдах

#### Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

### 3.2. ДОТООД ХЯНАЛТЫН ТАЛААР

#### Илрүүлэлт

Автотехник ашиглалтыг зориулалтын бус маягаар хөтөлсөн ба авто тээврийн газрын үзлэгийн болон шатахуун зарцуулалтын тэмдэглэгээ хийгдээгүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн ба хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна .

#### Зөвлөмж

Автотехник ашиглалтыг зориулалтын маягаар бүрэн хөтөлж хэвших

#### Хариуцах ажилтан

Дарга Б.Буяントонтох  
Нягтлан бодогч Б.Лүнгэрэгжанцан

#### Эрсдэл

Хөрөнгө үнэгүйдэж, ашиглалт хангалтгүй Хүлээн зөвшөөрсөн болох

#### Төсвийн захирагчийн хариу

## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	43,065,890.00	53,544,760.00
35	БАРАА МАТЕРИАЛ	43,065,890.00	53,544,760.00
35100	Түүхий эд материал	-	217,110.00
35130	Эм боох материал	-	217,110.00
35400	Хангамжийн материал	43,065,890.00	53,327,650.00
35410	Бичиг хэргийн материал	1,277,200.00	1,158,950.00
35420	Аж ахуйн материал	41,582,090.00	51,962,100.00
35430	Сэлбэг хэрэгсэл	206,600.00	206,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	2,358,434,146.17	2,303,815,010.09
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,358,434,146.17	2,303,815,010.09
39200	Биет хөрөнгө	1,323,638,516.05	1,269,281,879.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,291,330,713.23	1,291,330,713.23
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	-	(45,172,214.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	57,000,000.00	57,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(52,500,000.00)	(57,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	39,719,240.15	39,719,240.15
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(33,162,531.55)	(35,996,821.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,686,140.00	12,686,140.00
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(6,310,013.84)	(7,472,950.76)
39214	Бусад үндсэн хөрөнгө	65,329,100.00	65,329,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(50,454,131.94)	(51,141,326.46)
39300	Биет бус хөрөнгө	1,034,795,630.12	1,034,533,130.12
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(776,369.88)	(1,038,869.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,034,322,000.00	1,034,322,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	2,401,500,036.17	2,357,359,770.09
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
41300	Өглөг	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41312	НДШ-ийн өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	2,401,500,036.17	2,357,359,770.09
51	Засгийн газрын хувь оролцоо	2,401,500,036.17	2,357,359,770.09
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,475,624,319.00	2,475,624,319.00
51200	Хуримтлагдсан үр дүн	(390,714,544.41)	(434,854,810.49)
51210	Өмнөх үеийн үр дүн	(311,452,703.20)	(390,714,544.41)
51220	Тайлант үеийн үр дүн	(79,261,841.21)	(44,140,266.08)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зэрүү	316,590,261.58	316,590,261.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,401,500,036.17	2,357,359,770.09

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	358,168,442.69	419,142,955.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,858,972.69	28,276,050.00
1200	Нийтлэг татварын бус орлого	30,858,972.69	28,276,050.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,858,972.69	28,276,050.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	29,592,500.00	28,276,050.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	1,266,472.69	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	327,309,470.00	390,866,905.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,669,670.00	75,628,705.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчтэй бус этгээдээс авсан хандив, тусламж	61,053,600.00	-
131103	ЗГНХ, ЗДНХеренгэ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	-	2,544,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	21,616,070.00	72,626,005.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	458,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	244,639,800.00	315,238,200.00
132001	Ургал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	244,639,800.00	315,238,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	437,430,283.90	463,283,221.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	437,430,283.90	463,283,221.08
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	434,145,666.90	461,260,670.08
2101	Цалин, хэлс болон нэмэгдэл урамшил	146,715,419.00	163,276,725.00
210101	Үндсэн цалин	146,715,419.00	163,276,725.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,841,253.69	19,966,729.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,771,427.00	110,819,250.00
210301	Гэрэл, цахилгаан	9,799,805.00	11,452,415.00
210302	Түлш, халаалт	82,357,732.00	87,044,832.00
210303	Цэвэр, бохир ус	9,613,890.00	12,322,003.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,652,861.00	16,220,020.00
210401	Бичиг хэрэг	750,960.00	1,120,350.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	2,405,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,158,650.00	1,165,880.00
210405	Хог хаягдал зайлцуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	116,421.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	6,009,780.00	7,165,850.00
210408	Бараа материал актальсын зардал	8,377,050.00	4,122,440.00
2105	Нормативт зардал	-	85,010.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	85,010.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	1,693,700.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	1,693,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,131,685.00	2,798,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	160,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	972,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	213,705.00	215,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	112,500.00	112,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,000.00	132,000.00
210807	Газрын төлбөр	683,480.00	1,035,000.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	124,000.00	105,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	148,033,021.21	146,401,236.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,598,670.00	91,782,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	75,434,351.21	54,619,136.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,284,617.00	2,022,551.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,284,617.00	22,551.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,284,617.00	22,551.00
2132	Бусад ургал шилжүүлэг	1,000,000.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	2,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(79,261,841.21)	(44,140,266.08)
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(79,261,841.21)	(44,140,266.08)

#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	358,054,470.00	419,142,955.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,745,000.00	22,093,050.00
1200	Нийтлэг татварын бус орлого	30,745,000.00	22,093,050.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,745,000.00	22,093,050.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	29,592,500.00	22,093,050.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	1,152,500.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	327,309,470.00	397,049,905.00
1310	Улсын төсвөөс	244,639,800.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	244,639,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,669,670.00	81,811,705.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчтэй бус этгээдээс авсан хандив, тусламж	61,053,600.00	-
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	-	2,544,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	21,616,070.00	72,626,005.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	6,641,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	315,238,200.00
132001	Үргслэл үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	315,238,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	358,054,470.00	419,142,955.00
21	ҮРСГАЛ ЗАРДАЛ	358,054,470.00	419,142,955.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	354,769,853.00	417,120,404.00
2101	Цалин, хэлс болон нэмэгдэл урамшил	146,536,139.00	163,177,757.00
210101	Үндсэн цалин	95,932,500.00	140,720,797.00
210102	Нэмэгдэл	40,063,939.00	8,962,960.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	10,539,700.00	13,494,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,906,561.00	20,065,697.00
210201	Тэтгэврийн даатгал	16,906,561.00	20,065,697.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,771,427.00	110,819,250.00
210301	Гэрэл, цахилгаан	9,799,805.00	11,452,415.00
210302	Тулш, халаалт	82,357,732.00	87,044,832.00
210303	Цэвэр, бохир ус	9,613,890.00	12,322,003.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,475,171.00	9,253,500.00
210401	Бичиг хэрэг	786,500.00	1,100,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	2,323,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,158,650.00	1,165,880.00
210405	Хог хаягдал зайлцуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,290,021.00	4,424,020.00
2106	Эд хогшил, үргслэл засварын зардал	3,000,000.00	6,620,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,700,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	300,000.00
210604	Үргслэл засвар	3,000,000.00	3,620,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	1,693,700.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	1,693,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,131,685.00	2,798,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	160,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	972,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	213,705.00	215,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	112,500.00	112,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,000.00	132,000.00
210807	Газрын төлбөр	683,480.00	1,035,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	124,000.00	105,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,948,870.00	102,692,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,948,870.00	102,692,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,284,617.00	2,022,551.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,284,617.00	22,551.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,284,617.00	22,551.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	2,000,000.00

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны дүн
1	Үлдэгдэл	2,475,624,319.00	316,590,261.58	(390,714,544.41)	2,401,500,036.17
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,475,624,319.00	316,590,261.58	(390,714,544.41)	2,401,500,036.17
3	Тайлант үеийн үр дүн	-	-	(44,140,266.08)	(44,140,266.08)
	ҮЛДЭГДЭЛ	2,475,624,319.00	316,590,261.58	(434,854,810.49)	2,357,359,770.09

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Дүнгээр
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-	0
71701	Биеийн тамир спорт	337,238,200.00	337,246,750.00	-8,550.00
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	306,238,200.00	306,246,750.00	-8,550.00
12	Татварын бус орлого	306,238,200.00	306,246,750.00	-8,550.00
120	Нийтлэг татварын бус орлого	22,000,000.00	22,008,550.00	-8,550.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Үндсэн/	22,000,000.00	22,008,550.00	-8,550.00
122	Тусlamж, санхүүжилтийн орлого	284,238,200.00	284,238,200.00	0
122005	Төсвөөс санхүүжих	284,238,200.00	284,238,200.00	0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	306,238,200.00	306,246,750.00	-8,550.00
21	ҮРСГАЛ ЗАРДАЛ	306,238,200.00	306,224,199.00	14,001.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,238,200.00	306,224,199.00	14,001.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	162,652,000.00	162,651,797.00	203
210101	Үндсэн цалин	140,721,000.00	140,720,797.00	203
210102	Нэмэгдэл	8,437,000.00	8,437,000.00	0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,494,000.00	13,494,000.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,000,000.00	19,999,952.00	48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,826,200.00	106,819,250.00	6,950.00
210301	Гэрэл, цахилгаан	11,451,800.00	11,452,415.00	-615
210302	Түлш, халаалт	83,071,400.00	83,044,832.00	26,568.00
210303	Цэвэр, бохир ус	12,303,000.00	12,322,003.00	-19,003.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,930,000.00	7,930,000.00	0
210401	Бичиг хэрэг	800,000.00	1,100,100.00	-300,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	1,000,000.00	0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,390,000.00	1,165,880.00	224,120.00
210405	Хог хаягдал зайлцуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,500,000.00	4,424,020.00	75,980.00
2106	Эд хогшил, ургал засварын зардал	5,120,000.00	5,120,000.00	0
210601	Багаж, техник хэрэгсэл	1,200,000.00	1,200,000.00	0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	300,000.00	0
210604	Ургал засвар	3,620,000.00	3,620,000.00	0

2107	Томилолт, зочны зардал	1,700,000.00	1,693,700.00	6,300.00
210702	Дотоод албан томилолт	1,700,000.00	1,693,700.00	6,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж	2,010,000.00	2,009,500.00	500
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	215,000.00	215,000.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	113,000.00	112,500.00	500
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	66,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,000.00	132,000.00	0
210807	Газрын төлбөр	684,000.00	684,000.00	0
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	22,551.00	-22,551.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,000,000.00	29,000,000.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	0

#### **4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
71701	Биеийн тамир спорт	89,026,370.00	81,790,705.00
80102	Туслах үйл ажиллагааны зардал	46,356,700.00	8,446,705.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДУН	46,356,700.00	8,446,705.00
21	ҮРСГАЛ ЗАРДАЛ	46,356,700.00	8,446,705.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,356,700.00	8,446,705.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	525,960.00
210102	Нэмэгдэл Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,200,939.00	525,960.00
2102	Тэтгэврийн даатгал	-	65,745.00
210201	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,920,561.00	65,745.00
2103	Түлш, халаалт	-	4,000,000.00
210302	Хангамж, бараа материалын зардал	-	4,000,000.00
2104	Тээвэр, шатахуун	-	1,323,500.00
210402	Эд хогшил, ургал засварын зардал	-	1,323,500.00
2106	Багаж, техник хэрэгсэл	-	1,500,000.00
210601	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж	-	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	704,000.00
210801		-	160,000.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	172,000.00
210807	Газрын төлбөр	-	351,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,235,200.00	348,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,235,200.00	348,500.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ YYCBЭР	46,356,700.00	8,446,705.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,356,700.00	8,446,705.00
	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн		
131104	захирагчид хуваарилсан х	40,000,000.00	1,826,005.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,356,700.00	6,620,700.00
80305	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	-	73,344,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	73,344,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	73,344,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,669,670.00	73,344,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	73,344,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,669,670.00	73,344,000.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ YYCBЭР	-	73,344,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,669,670.00	73,344,000.00
	ЗГНХ,ЗДНХөрөнгө,туунтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн		
131103	захирагчид хуваарилсан	21,053,600.00	2,544,000.00
	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн		
131104	захирагчид хуваарилсан х	21,616,070.00	70,800,000.00

АжтЫН БЕРИМТЫН ИЕР:

АКДЫН ІЗДЕРГИЛІК ЛУПЛА:

Аудитні наці:

3/10

MAGNETIC RESONANCE

ИСЛЯДЫ

**Загружаю борг штрафы на баланс, зерчилтэй асуудлын бүртэл**

ECA-2020/02/CTA-TII/2

АЙМГИЙН "БИЕИЙН ТАМИР СЛОВТЫН ГАЗАР"

№	Аудитын чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийцэл	Аудитын байгууллагасан шийцэл	Гаргасан шийцэл	Албан тушал	Үйлчилгүүлэгч байгууллагын талаас алдаа,	Овог нар	10
A	A	2	3	4	5	6	7	8	9	Дарга, Нягтлан бодоч	Д.Буянтотгох, Б.Лүнгэрэжсанчан
1	Зардал	1	Буцааж тушавсан амралтын зөвүүг буруу бургассан	167.7	Зарууллах	Зөвшөөрсөн	Заруулсан		Дарга, Нягтлан бодоч	Дарга, Нягтлан бодоч	Д.Буянтотгох, Б.Лүнгэрэжсанчан
2	Орлогого	1	Орлогийн бодилтой төвлөвлөгүйгээс орлогийн жил бүр давхь, наамээлт санхүүжилтийн дэнсаар зарынгуулсан	6,183.0	Албан шаардлагатай егэх	Тайлбаргтай	Өөрчлөгдсөнгүй	Зөвлөмж егэх	Дарга, Нягтлан бодоч	Дарга, Нягтлан бодоч	Д.Буянтотгох, Б.Лүнгэрэжсанчан
3	Зардал	1	Холбогны зэрэлтийн томилгоптын зэрэлтийн давхардаулан алгосон	63.0	Төлбөрийн акт тоогох	Зөвшөөрсөн	Өөрчлөгдсөнгүй	Төлбөрийн акт тоогох	Дарга, Нягтлан бодоч	Дарга, Нягтлан бодоч	Д.Буянтотгох, Б.Лүнгэрэжсанчан
4	Элэгдлийн зэрдал	1	Үндсэн хөрөнгийн эзлэгдлийн зэрэлтиг илүү тайлланысан	216,475.8	Зөвлөмж егэх	Зөвшөөрсөн	Өөрчлөгдсөнгүй	Зөвлөмж егэх	Дарга, Нягтлан бодоч	Дарга, Нягтлан бодоч	Д.Буянтотгох, Б.Лүнгэрэжсанчан
5	Дотоод хийнхт	1	Автомехник ашиглалтын, зориулалтын бус дэвтэрт хөгжсөн ба авто тээврийн гарын узэгээс болон шатахуун засцуулалтын тэмдээлэлээг хийдээгүй байна.	-	Зөвлөмж егэх	Зөвшөөрсөн	Өөрчлөгдсөнгүй	Зөвлөмж егэх	Дарга, Нягтлан бодоч	Дарга, Нягтлан бодоч	Д.Буянтотгох, Б.Лүнгэрэжсанчан
6	Үндсэн хөрөнгө	1	Ашиглалтын хугацаа дурссан, үндсэн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэгчийн	-	Зөвлөмж егэх	Зөвшөөрсөн	Өөрчлөгдсөнгүй	Зөвлөмж егэх	Дарга, Нягтлан бодоч	Дарга, Нягтлан бодоч	Д.Буянтотгох, Б.Лүнгэрэжсанчан

માનવ

Албан тушаал, овог нэр, гарын үсэг

Анхан шатанд хянасан:

Албан тушаал, овог нэр, гарын  
Аудитын менежер  
Хоёр дахь шатанд хянасан:

Албан тушаал, овог нэр, гарын усэг  
Дарга, Тэргүүлэх аудитор

10

11

**Танынцаң 388шөөрсөн:**  
Биенй Тайир спортын газар"-ын

卷之三

Бүнгээрэгжсанцан  
Нягтлан бодогч  
Огноо:

Сарантуяа

Онгыз  
427-14000  
УСА0055 9030040



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР  
АКТ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 01/04

Чойр

Төлбөр тогтоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Говьсүмбэр аймгийн "Биеийн тамир спортын газар"-ын 2019 оны санхүүгийн тайланийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Тайлант онд албан томилолтоор ажилласан хугацаанд хоолны мөнгийг давхардуулан 63.0 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.2.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Давхардуулан олгосон 63,000.00 төгрөгийг холбогдох этгээдээр төлүүлж, аймгийн Төрийн сан дахь Орон нутгийн орлогын /Төсөвт байгууллагын өөрийн орлого/ 100220000954 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2020 оны 03 дугаар сарын 20-ны дотор гаргаж, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Биеийн тамир, спортын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Буяントогтох, нягтлан бодогч Б.Лүнгэрэгжанцан нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:  
АУДИТОР: Д.ОЮУНБАТ  
ХЯНАСАН:  
АУДИТИН МЕНЕЖЕР: Г.НАРАНБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:  
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР,  
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ: Б.БУЯНТОГОХ

НЯГТЛАН БОДОГЧ: Б.ЛҮНГЭРЭГЖАНЦАН

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангаадаааүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

0800000135



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 01/12

Чойр

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн “Биеийн тамир, спортын газар”-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Үндсэн үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөөгүйгээс орлого жил бүр давж биелсэн бөгөөд төлөвлөгөөнөөс давсан орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тогтоолын 3.4.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны A/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1 дэх заалтыг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Үндсэн үйл ажиллагааны орлогыг бодитой, үнэн зөв төлөвлөж байх
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 09 дүгээр сарын 25-ны дотор гаргаж, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Биеийн тамир, спортын газрын даргын ургийг түр орлон гүйцэтгэгч Б.Буянтогтох, нягтлан бодогч Б.Лүнгэрэгжанцан наарт хариуцуулав.

ӨГСӨН<sup>1</sup>:

АЛБАН ШААРДЛАГЫГ

АУДИТОР

*Долж*

ДОЮУНБАТ

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

*Г.НАРАНБАЯР*

ЗӨВШӨӨРСӨН:

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БИЕИЙН  
ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

*М.Исбат*

00009 90-8573

Б.БУЯНТОГОХ

*Б.Буянтогтох*

Б.ЛҮНГЭРЭГЖАНЦАН

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлтийг хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелуулзэгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрээт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хургуулна.

0800000204